

## ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ХЯНАЛТЫН КАТЕР АШИГЛАХ ТЕХНИКИЙН ЗААВАР

Усан замын тээврийн хэрэгсэл, хяналтын катерын техник ашиглалтын зааврын зорилго нь тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж болон тэдгээрийн ашиглалт, засвар, үйлчилгээнд тавигдах шаардлага, хяналтын катер жолоодогчийн ажиллах горимыг тогтооход оршино.

Усан замын тээврийн хэрэгсэл жолоодогч нь усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, диплом, гэрчилгээтэй байна.

### 1. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООДОГЧ АЯЛАЛД ГАРАХЫН ӨМНӨ АНХААРАХ ЗҮЙЛС

1. Усан замын тээврийн хэрэгсэлд зайлшгүй байх эд хэрэгслийг бүртгэж, шалгана. Үүнд:
  - Аврах хантааз;
  - Аврах цагираг;
  - Дуут дохио (шүгэл);
  - Гар чийдэн;
  - Аврах олс (10-20 метрийн урттай);
  - Хувин, шанага (завьны ёроол цоорсон тохиолдолд усыг гадагшлуулах);
  - Сэлүүр;
  - Зангуу болон олс;
  - Анхан шатны тусламж үзүүлэх эмийн сан;
  - Засварын багаж хэрэгсэл орно.
2. Техникийн бүрэн бүтэн байдлыг шалгана. Үүнд:
  - Усан замын тээврийн хэрэгслийн ёроолд ус орсон эсэх, их биеийн гадна, дотор цооролт шинээр үүссэн эсэх;
  - Радио холбооны хэрэгсэл болон байршил тогтоох систем, (GPS) тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэх;
3. Хөдөлгүүрийн хэвийн ажиллагааг шалгана. Үүнд:
  - Шатахууны хэмжээ, болон тос маслын хэмжээ хэвийн түвшинд байгаа эсэх;

- Хөдөлгүүр асаахын өмнө хурдны хайрцагны удирдах хөшүүрэг нейтрал буюу N байрлалд шилжүүлсэн эсэхийг анхаарах;
  - Завь, катерыг зогсоолд бүрэн байрлуулж бэхлэсний дараа хөдөлгүүрийг асааж, унтраах;
  - Хөдөлгүүрийн ус хөргөөгч систем ажиллах байгаа эсэхийг шалгана.
4. Зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс дараахь аюулгүй ажиллагааны зааварчилгааг зорчигчдод танилцуулна. Үүнд:
- Аврах хантааз хэрхэн өмсөх талаар зааварчилгааг зорчигчдод танилцуулан аврах хантаазыг зорчигчдын тоогоор өмсгөх;
  - Зорчигчид усан замын тээврийн хэрэгслийн жолоодогч, ахмад түүний багийн гишүүдэд шууд захирагдах үүрэгтэй;
  - Зорчигчид зөвхөн усан замын тээврийн хэрэгсэл жолоодогч /ахмад/- ийн зөвшөөрлийн дагуу усан замын тээврийн хэрэгсэл /завь, катер, усан онгоц/-д хуваарилсны дагуу суух;
  - Бага оврын завь, катерыг савлуулах мөн усан замын тээврийн хэрэгслийн нэг талд бөөгнөрч хазайлт үүсгэхийг хориглох;
  - Хийлдэг завь болон жижиг оврын завин дээр зогсоогоор аялахыг хориглоно.

## 2. ХӨДӨЛГӨӨН ЭХЛҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

1. Автоматаар хөдөлгүүр унтраах хавхлагийг завь жолоодогчийн аврах хантаазнаас бэхлэнэ. (Энэ нь тээврийн хэрэгсэл жолоодох, удирдлага алдагдсан үед автоматаар хөдөлгүүрийг унтрааж тээврийн хэрэгслийг зогсоох найдвартай арга юм);
2. Хөдөлгүүрийг бүрэн гүйцэд шалгаж ямар нэгэн доголдол ажиглагдаагүй нөхцөлд хөдөлгүүрийг асааж зогсоолоос хөдөлнө;
3. Завь, катерыг аялалд бэлтгэн, аялалд гарахаас өмнө усны урсгал болон салхины чигийг тодорхойлж шалгах ба зогсоолоос хөдлөхдөө усны гүн, моторын суулт сэнсний эргэлтийг давхар шалгана;
4. Зогсоолоос хөдлөхдөө хөдөлгүүрийн сэнсний эргэлтийг хамгийн бага хурдаар эхлүүлэх ба зогсоол орчимд давалгаа үүсэхгүй байхаар тооцно.

## 3. ЖОЛООДОГЧИЙН ЧАДАМЖ

Усан замын тээврийн хэрэгсэл, хяналтын катер жолоодогч нь дараахь чадварыг бүрэн эзэмшсэн байна. Үүнд:

1. Завь, катерыг аюулгүйгээр жолоодон, 180 градусаар огцом эргэлт хийх;
2. Завь, катераар 360 градуст тойрог хөдөлгөөн хийх;
3. Зогсоолд завьны хажуу хэсгээр аюулгүй байршуулах;
4. Усанд унасан хүнд тусламж үзүүлэхүйц хэмжээнд ойртон очих (тусламж үзүүлэхээр дөхөж очихдоо тухайн этгээдэд давалгаа үүсгэж, их хэмжээний усаар дарж нөхцөл байдлыг хүндрүүлэхгүй байх);
5. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;
6. Завь, катерын хурдыг тохируулах ба хөдөлгүүрийн хүчин чадлыг тооцоолох;
7. Завь, катерыг зогсоолд байрлуулахаас гадна завь, катерын их бие, урд тал, хойд талаас зогсоол болон усны урсгалд тохируулан бэхлэх зэрэг анхан шатны мэдлэг чадваруудыг бүрэн эзэмшсэн байна.

-----oOo-----